

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

## АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	8
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	9
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
	Тайлант онд төсөвт төвлөрүүлэх орлого төлөвлөөгүй байна. ....	11
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал .....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	21

## 1 Аудитын гэрчилгээ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/245  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН  
АЛБАНЫ ДАРГА Т.НОМИН ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Yawsan\_Bichig\2019\0224SAG25.Docx

370581

### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давсан нь "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:


- Үндэсний зөвлөлийн гишүүдийн урамшууллын дээд хэмжээг Улсын Их Хурлын Байнгын хороогоор батлуулаагүй, сар бүр тооцон олгосон;
- Анхан шатны баримт бүрдэл дутуу 3,324.0 мянган төгрөгийн зардал бүртгэсэн;
- Тайлант оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 2,010.6 мянган төгрөгийг төсвийн ерөнхий дансанд буцаан төвлөрүүлээгүй;
- Санхүүгийн програмын засвар үйлчилгээ, хуралдааны тараах материал хэвлэх, бэлтгэл хангахад зориулж 1,821.9 мянган төгрөг зарцуулсан нь гэрээ, анхан шатны баримт, ерөнхий журналын бичилт зөрчилтэй, зардлыг нотлох боломжгүй;
- Бараа материалын тодруулга тайлангаар 8,175.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 6,003.1 мянган төгрөгийг зарцуулж, 2,172.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан боловч дэлгэрэнгүй тайлан гаргаагүй, анхан шатны баримт бүрдүүлээгүй;
- Санхүүгийн байдлын тайланд 5,355.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө (анхны өртгөөр), 2,172.7 мянган төгрөгийн бараа материал тайлагнасан боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй;
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын ангилалаас хуралдааны бэлтгэл, гарын авлага, товхимол бэлтгэхэд зориулж 2,900.0 мянган төгрөг шилжүүлж, шууд зардалд бүртгэсэн байна.

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга Т.Номинд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 05-ны өдөр-наас 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Л.Мөнхцацрал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдөрны өдрийн №10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах бодлого, зохицуулалтаар хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг актуар тооцоололд үндэслэн боловсруулах,

- батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, үйл ажиллагааны болон удирдлагын зардлыг хянах, үнэлэлт, дүгнэлт өгөх;
  - Эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх;
  - Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтыг эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;
  - Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн дээд хязгаар, энэ хуулийн 11.2-т заасан даатгуулагчийн төлөх төлбөрийн хэмжээг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тухай бүр тогтоох;
  - Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох;
  - Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах зэрэг байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлэгийн тусламж үйлчилгээний тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 06 дугаар сарын 02-ны 40 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийг 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны “Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай” 2017 оны 7 дугаар сарын 05-ны 27 дугаар тогтоолыг үндэслэн Ажлын албаны чиг үүрэг, бүтэц, орон тоо батлагджээ.



Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн "Ажлын албаны дүрэм батлах тухай" 2018 оны 20 дугаар тогтоолоор ажлын албаны орон тоог 12 болгон батласан байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь 2018 оноос санхүүгийн тайлан толилуулж байгаа тул Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөөгүй 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд шинээр боловсруулахаар тусган ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд энгийн буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous" програм хангамж ашигладаг байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "их" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй тул үр нөлөөгүй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны төсвийн нийт орлогын 2 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь 2018 онд санхүүгийн тайлан толилуулж буй шинээр үүсгэн байгуулагдсан учир эрсдэл өндөртэй гэж тооцон (нийт орлого 147,428.8 мянган төгрөг) сонгосонтой холбоотой юм.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны Нийт орлого 147,428.8 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 2,948.58 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс 2 хувиар тооцсон нь дээр дурдсан эрсдлийн түвшин өндөр гэж тооцсонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	18,604.20	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	3,832.50	

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	Албан шаардлага өгсөн	2	12,950.50
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00
	Дүн	7	35,387.20

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөхийг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчлийг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Үндэсний зөвлөлийн гишүүдийн урамшууллын дээд хэмжээг Улсын Их Хурлын Байнгын хороогоор батлуулаагүй сар бүр тооцон олгосон;
2. Анхан шатны баримт бүрдэл дутуу 3,324.0 мянган төгрөгийн зардал бүртгэсэн зэрэг 12,950.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.
3. Тайлант оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 2,010.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлээгүй;
4. Санхүүгийн програм, засвар үйлчилгээ, хуралдааны тараах материал хэвлэх, бэлтгэл хангахад зориулж 1,821.9 мянган төгрөг тус тус зарцуулсан боловч гэрээ, анхан шатны баримт, ерөнхий журналын бичилт зөрчилтэй, бараа материалын бүртгэлээр нотлох боломжгүй байгаа зэрэг нийт 3,832.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд аудитын акт тогтоосон болно.

### 2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 -1.1-д " Эрүүл мэндийн даатгалын удирдах дээд байгууллага нь Үндэсний зөвлөл байна" гэж заасны дагуу хуулиар хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2018 онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны ажиллагсдын цалингийн зардлыг төсөвт суулгалгүй, гишүүдийн урамшууллын ангиллаас олгосон нь эх үүсвэрийн дутагдал бий болгосон байна. 2019 онд цалингийн сан хүрэлцэхгүй болох дээрх нөхцөл бүрдсэн байна.

2.УИХ-ын байнгын хорооны 2018 оны 18 дугаар тогтоолоор ажлын албаны ажиллагсдын тоог 12 болгон нэмэгдүүлсэн нь одоогийн байршиж буй 70.8 мквт ажлын байрны талбай хүрэлцэхгүй, стандарт хэмжээнд хүрэхгүй болох төлөвтэй байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хуулиар хүлээсэн үүргийг биелүүлэх, Ажлын албаны үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбоотой төсөв санхүүгийн хүрэлцээ, ажлын нөхцлийг хангах асуудал анхаарал татаж байна.

### 2.10 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 8 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 147,428.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 145,418.2 мянган төгрөг буюу 99 хувьтай байна. Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал бүлгийн хэмжээнд хэмнэгдсэн боловч урамшууллын зардлын эх үүсвэрээс ажлын албаны ажиллагсдын цалинг олгосноос 4,437.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлын эх үүсвэрээс хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотойгоор эд хогшил худалдан авах зардал 351.9 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн байна. Бусад зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулжээ.

## **ТАЙЛАНТ ОНД ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.**

### **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх онд санхүүгийн тайлан толилуулаагүй байна.

### **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1.1 Илрүүлэлт

Бараа материалын тодруулга тайлангаар 8,175.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 6,003.1 мянган төгрөгийг зарцуулж, 2,172.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Гэвч бараа материалын дэлгэрэнгүй тайланг бэлтгээгүй, анхан шатны баримт бүрдүүлээгүй байгаа нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, бодитой, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь ... үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." гэж заасанд нийцэхгүй байна.

#### Өгсөн зөвлөмж :

Бараа материалын дэлгэрэнгүй тайлан гаргаж, холбогдох баримтыг бүрдүүлж ажиллах

**Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулахад хүлээн зөвшөөрсөн болно.

#### 3.2.1 Илрүүлэлт

ЭМДҮЗ-ийн 2018 оны санхүүгийн тайлангаар 5,355.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө /анхны өртгөөр/, 2,172.7 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлагнасан боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, тулган баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" гэж заасанд нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Хуулийн дагуу жилийн эцсийн хөрөнгө тооллогыг гүйцэтгэж, баталгаажуулах

**Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулахад хүлээн зөвшөөрсөн болно.

**3.3.1 Илрүүлэлт**

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын ангиллаас хуралдааны бэлтгэл, гарын авлага, товхимол бэлтгэхэд зориулж 2,900.0 мянган төгрөг шилжүүлж, шууд зардалд бүртгэсэн байна. Аудитын явцад дээрх гүйлгээнд нэмэлт сорил хэрэгжүүлэхэд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаан зохион байгуулахад 1 гишүүний нэг удаагийн хуралдааны зардлыг 64.9 мянган төгрөгөөр тооцон бусдаар гүйцэтгүүлэх гэрээ байгуулан урьдчилан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтад нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан Төсвийн зарлагын эдийн засгийн ангилалыг ашиглах заавар, Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалаар баталсан санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалыг мөрдөж ажиллах

**Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Алдаа зөрчилтэй асуудлыг В501 маягтаар хураангуйлан байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулахад хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019.06.15-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

#### АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>5,083,521.85</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>		2,010,565.85
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>		2,010,565.85
<b>3121</b>	<b>Төгрөг</b>		2,010,565.85
31211	Төрийн сангийн харилцах		2,010,565.85
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		900,252.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>		900,252.00
3351	Байгууллагаас авах авлага		900,252.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		2,172,704.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>		2,172,704.00
35410	Бичиг хэргийн материал		196,422.00
35420	Аж ахуйн материал		515,996.00
35440	Түлш, шатах тослох материал		165,000.00
35470	Бусад хангамжийн материал		1,295,286.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>4,872,387.34</b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>		
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		4,872,387.34
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>		4,872,387.34
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		5,355,714.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		-483,326.66
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>9,955,909.19</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>854,321.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		854,321.00
<b>413</b>	<b>Өглөг</b>		854,321.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>9,101,588.19</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		9,101,588.19
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		9,101,588.19
51210	Өмнөх үеийн үр дүн		
51220	Тайлант үеийн үр дүн		9,101,588.19
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>9,955,909.19</b>

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

СТ-2А

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		147,428,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		147,428,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		147,428,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		147,428,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		138,327,211.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ		138,327,211.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		137,745,011.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		108,394,026.15
210101	Үндсэн цалин		
210102	Нэмэгдэл		12,914,451.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		3,643,242.00
210104	Урамшуулал		91,836,333.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		11,680,577.00
210201	Тэтгэврийн даатгал		7,359,477.00
210202	Тэтгэмжийн даатгал		1,084,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		795,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал		271,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал		2,169,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал		6,086,082.00
210401	Бичиг хэрэг		1,860,994.00
210402	Тээвэр, шатахуун		2,335,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,890,088.00
2107	Томилолт, зочны зардал		3,324,000.00
210702	Дотоод албан томилолт		3,324,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,140,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,140,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		7,120,326.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		6,637,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		483,326.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		582,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		582,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		582,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		9,101,588.19
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		9,101,588.19



#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

#### АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>		<b>147,428,800.00</b>
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>		147,428,800.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		147,428,800.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>		<b>140,062,520.15</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>140,062,520.15</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>139,480,320.15</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		107,121,634.15
210101	Үндсэн цалин		
210102	Нэмэгдэл		12,914,451.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		3,643,242.00
210104	Урамшуулал		90,563,941.15
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		12,998,900.00
210201	Тэтгэврийн даатгал		8,677,800.00
210202	Тэтгэмжийн даатгал		1,084,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		795,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал		271,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал		2,169,500.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		6,294,589.00
210401	Бичиг хэрэг		2,034,600.00
210402	Тээвэр, шатахуун		2,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,759,989.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		135,997.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		135,997.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		3,324,000.00
210702	Дотоод албан томилолт		3,324,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		1,140,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,140,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		8,465,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		8,465,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>582,200.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		582,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		582,200.00

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>		<b><u>7,366,279.85</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>		<b>5,355,714.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>5,355,714.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		5,355,714.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		5,355,714.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>		<b><u>-5,355,714.00</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		2,010,565.85
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		2,010,565.85

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	9,101,588.19	00.00	9,101,588.19
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	9,101,588.19	00.00	9,101,588.19

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

#### АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	147,428,800.00	145,418,234.15	2,010,565.85	99%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	147,428,800.00	145,418,234.15	2,010,565.85	99%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	146,846,600.00	144,836,034.15	2,010,565.85	99%
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	108,473,000.00	107,121,634.15	1,351,365.85	99%
210101	Үндсэн цалин				
210102	Нэмэгдэл	13,106,700.00	12,914,451.00	192,249.00	99%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,240,000.00	3,643,242.00	5,596,758.00	39%
210104	Урамшуулал	86,126,300.00	90,563,941.15	(4,437,641.15)	105%
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,016,700.00	12,998,900.00	17,800.00	100%
210201	Тэтгэврийн даатгал	8,677,800.00	8,677,800.00	-	100%
210202	Тэтгэмжийн даатгал	1,084,700.00	1,084,700.00	-	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	867,800.00	795,300.00	72,500.00	92%
210204	Ажилгүйдлийн даатгал	216,900.00	271,600.00	(54,700.00)	125%
210205	Эрүүл мэндийн даатгал	2,169,500.00	2,169,500.00	-	100%
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,906,500.00	6,554,589.00	351,911.00	95%
210401	Бичиг хэрэг	2,034,600.00	2,034,600.00	-	100%
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	2,500,000.00	-	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,371,900.00	2,019,989.00	351,911.00	85%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,580,000.00	2,931,911.00	(351,911.00)	114%
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,580,000.00	2,931,911.00	(351,911.00)	114%
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	3,965,400.00	3,324,000.00	641,400.00	84%
210702	Дотоод албан томилолт	3,965,400.00	3,324,000.00	641,400.00	84%
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,500,000.00	2,500,000.00	-	100%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	2,500,000.00	-	100%
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	9405000.00	9405000.00	-	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,405,000.00	9,405,000.00	-	100%

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	582,200.00	582,200.00	-	100%
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	582,200.00	582,200.00	-	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	582,200.00	582,200.00	-	100%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	147,428,800.00	147,428,800.00	-	100%
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	147,428,800.00	147,428,800.00	-	100%
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	147,428,800.00	147,428,800.00	-	100%
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	2,010,565.85	(2,010,565.85)	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01.00	01.00	-	100%
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	-	100%
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	23.00	14.00	9.00	61%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	13.00	7.00	65%
620004	Гэрээт ажилтан	02.00	00.00	2.00	
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>23.00</b>	<b>14.00</b>	9.00	61%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00	-	100%
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)				
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	10.00	03.00	7.00	30%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	01.00	01.00	-	100%
650010	Гэрээт ажилтан	02.00	00.00	2.00	
650011	Улс төрийн албан хаагч (УТ)				

## 5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
				САГ-2019/408/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл			сая төгрөгөөр

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Үндэсний зөвлөлийн гишүүдийн урамшууллын дээд хэмжээг Улсын Их Хурлын Байнгын хороогоор батлуулаагүй, сар бүр тооцон олгосон;	9.6	Албан шаардлага	Ажлын албаны дарга, Нягтлан бодогч-аудитор	Т.Номин Д.Энхдулам
Анхан шатны баримт бүрдэл дутуу 3,324.0 мянган төгрөгийн зардал бүртгэсэн	3.3	Албан шаардлага		
Тайлант оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 2,010.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлээгүй	2.0	Акт		
1,821.9 мянган төгрөгийн зардлын гэрээ, анхан шатны баримт, ерөнхий журналын бичилт зөрчилтэй, бараа материалын бүртгэлээр нотлох боломжгүй	1.8	Акт		
Бараа материалын дэлгэрэнгүй тайланг бэлтгээгүй, анхан шатны баримт бүрдүүлээгүй	8.2	Зөвлөмж		
ЭМДҮЗ-ийн 2018 оны санхүүгийн тайлангаар 5,355.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө /анхны өртгөөр/, 2,172.7 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэл тайлагнасан боловч жилийн эцсийн хөрөнгө тооллого хийгээгүй, тулган баталгаажуулаагүй	7.5	Зөвлөмж		
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын ангилалаас хуралдааны бэлтгэл, гарын авлага, товхимол бэлтгэхэд зориулж 2,900.0 мянган төгрөг шилжүүлж, шууд зардалд бүртгэсэн	2.9	Зөвлөмж		
<b>Зөрчлийн дүн</b>	<b>35.3</b>			



